



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2025 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 404

Улаанбаатар хот

**Төрийн өмчийн төлөөлөгч бөгөөд гүйцэтгэх
захирлын үүрэг гүйцэтгэгч томилох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, 9 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 4, 6 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал томилогдох хүртэлх хугацаанд Аминдаваагийн Молорыг Төрийн өмчийн төлөөлөгч бөгөөд гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдрөөс эхлэн томилсугай.

2.“Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд Төрийн өмчийн төлөөлөгч бөгөөд гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Аминдаваагийн Молортой Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулахыг удирдамж болгосугай:

3.Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан, хууль журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллах, компанийн дүрэм, бүтэц болон эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг боловсруулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар шийдвэрлүүлэхийг Төрийн өмчийн төлөөлөгч А.Молорт даалгасугай.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ